



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/148

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 04 дүгээр, 03 дугаар сарын 14-ний өдрийн 13 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/202212099 дугаартай сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2023 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 1, 2, 4, 11, 16, 23 багц ажлуудыг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т олгосугай.

2.Хууль тогтоомжид нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т даалгасугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ